

## Халуун усны барилга / Баян-Өлгий, Сагсай сум /-ын ажил гүйцэтгэх гэрээ

2020 оны 11 дугаар  
сарын 29-ны өдөр

Дугаар: 2020/236

Улаанбаатар  
хот

Нэг талаас Барилга, хот байгуулалтын яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “ӨЛКЕ КОНСТРАКШН” ХХК (цаашид “гүйцэтгэгч” гэх) харилцан тохиролцож энэ гэрээг байгуулав.

1. Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэ гэрээний зорилго оршино.

2. Захиалагч нь Халуун усны барилга /Баян-Өлгий, Сагсай сум/-ын ажил (цаашид “ажил” гэх) ажлыг **253,917,336 хоёр зуун тавин гурван сая есөн зуун арван долоон мянга гурван зуун гучин зургаа** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх)/ Үүнд: Инженер хайгуул, зураг төслийн ажлын үнэ 9,990,000 төгрөг, зураг төсөл зохиогчийн хяналтын зардал 2,474,883 төгрөг, магадлашгүй ажлын зардал 4,949,766 төгрөг, нормчлолын сангийн зардал 445,479 төгрөг, захиалагчийн хяналтын зардал 4,949,766 төгрөг/-өөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: 253,917,336 төгрөг. Үүнээс:  
2020 онд: 50,000,000 төгрөгөөр санхүүжүүлнэ.

4. Гүйцэтгэгч нь Халуун усны барилга /Баян-Өлгий, Сагсай сум/-ын ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр эхэлж, 2021 оны 07 дугаар сарын 16-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Доор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг;
- 5.3. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.5. Техникийн тодорхойлолт;
- 5.6. Зураг;
- 5.7. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь;
- 5.8. Санхүүжилтийн хуваарь;

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр, эсхүл утсан холбоогоор харилцана.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

 С.МАГНАЙСҮРЭН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ  
САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА

 Э.ГАНХҮҮ

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ  
САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ГАЗРЫН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА


 С.ДОЛЖИНСҮРЭН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ,  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.НЯМДОРЖ

Хаяг: 15170 УБ, Чингэлтэй дүүрэг,  
Барилгачдын талбай 3, Утас: 31-06-12,  
факс 32-29-04,  
E-mail: [info@mcud.gov.mn](mailto:info@mcud.gov.mn)  
<http://www.mcud.gov.mn>

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨААТҮГ-  
ЫН ЗАХИРАЛ

 Ц.АМАРСАНАА


Хаяг: Улаанбаатар хот, Чингисийн өргөн  
чөлөө-11, Засгийн газрын байр-13  
Утас: 32-24-06, ФАКС: 31-23-15

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ӨЛКЕ КОНСТРАКШН”  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

 А.АХМАРАЛ

“ӨЛКЕ КОНСТРАКШН”  
ХХК-ИЙН ИНЖЕНЕР

 Д.ЖАНБОЛАТ

Хаяг: Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг, 8-р хороо,  
Улаанхуаран гудамж 64-66  
тоот  
Утас: 99222186, 88093996  
e-mail: [akhmaral.mn@gmail.com](mailto:akhmaral.mn@gmail.com)  
Харилцагч банкны нэр: Хаан  
банк  
Данс: 5653151053  
Регистрийн дугаар: 6216862